



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-ҮҮР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/81

Цагаан-Үүр сум

“Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэн
өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны Ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны “Нэрлэсэн жилийн үйл ажилагааны төлөвлөгөө батлах тухай” А/81 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн үндэсний байгууллагын ерөнхий ассамблейн шийдвэрээр жил бүрийн 05 дугаар сарын 15-ны өдрийг “Олон улсын гэр бүлийн өдөр” болгон зарласан учир төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэд тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэсүгэй.

2. “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг сумын бүх шатны төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагууд гэр бүл, хүүхэд, хөгжил хамгааллыг дэмжсэн төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч, захирал, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. “Олон улсын гэр бүлийн өдөр”-т зориулагдах төсөв санхүүг хууль, тогтоомжийн хүрээнд байгууллага, аж ахуйн нэгжүүд жил бүрийн төсөвтөө тусган ажиллахыг тухайн байгууллагын дарга, эрхлэгч, захирал, нягтлан бодогч нарт даалгасугай.

4. Гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн ажлын тайланг тухайн жилийн 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Сарныгэрэл)-д цаасан болон файл хэлбэрээр нэгтгэж хүргүүлэхийг төрийн болон төрийн бус байгууллагын дарга, эрхлэгч, захирал, багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (С.Үүрийнбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТМӨНХ

Му сом\Д\захирамж\

6704301094